



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II, III ТӨСӨЛ
BMZ №2016 67 054, 2018 68 272

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ЭЦСИЙН ТАЙЛАН

Захиалагч байгууллага: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Санхүүжүүлэгч байгууллага: ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН
СЭРГЭЭН БОСГОЛТЫН ЗЭЭЛИЙН (KfW) БАНК

Гүйцэтгэгч байгууллага: “И ЭМ ТЕХНОЛОГИ” ХХК

Гэрээний нэр: “Төслийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, контент боловсруулах,
танилцуулах” №ГШБ-4.04/2123

Гэрээний дугаар: 23/259

Тайланг боловсруулж хүргүүлсэн: “И ЭМ ТЕХНОЛОГИ” ХХК-ийн

Захирал..... Ц.Билэгсайхан


Technology



2024 оны 1 дүгээр сарын 19 өдөр
Улаанбаатар хот

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ЭЦСИЙН ТАЙЛАН

Төсөл арга хэмжээний зорилго, үндэслэл:

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан тусгай хамгаалалттай газар нутгийн онцлог, хүн байгаль, зэрлэг ан амьтантай зөв зохистой харьцах харилцааг олон нийтэд сурталчлах түгээх, байгаль хамгаалагчийн ажлын онцлог, тулгамдаж буй асуудлын тухай бодит мэдээллээр хангах;

Хамрах хүрээ:

Байгаль хамгаалагчийн ажлын онцлог, тулгамдаж буй асуудлын тухай бодит мэдээллээр хангах хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн 4 хамгаалалтын захиргааны 3-5 байгаль хамгаалагчдыг хамруулна. Үүнд:

1. Мянган угалзатын нурууны БЦГ
2. Говийн их ДЦГ-ийн Б хэсэг
3. Хан хөхийн нурууны ЦТХГН
4. Увс нуурын УТХГН

Хийх ажлын бүрдэл:

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дараах ажлуудаас бүрдэнэ:

Богино 5 минутын 4 контент, 4 контентыг нэгтгэсэн урт хувилбар буюу 15 минутын 1 контент, 1 минутын 8 ширхэг Рийл/REEL хийн олон нийтийн цахим сүлжээнд түгээх. Тус контентуудыг өргөн нэвтрүүлгийн 2 телевизээр (МҮОНТ, NTV) олон нийтэд нэвтрүүлэх юм.

Тус ажлын хүрээнд дараах 5 бүтээгдэхүүний гаргаж төслийн захиалагчид хүргүүлж байна. Үүнд:

1. Байгаль хамгаалагч гэж хэн бэ? сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулах, өргөн нэвтрүүлгийн 2 сувгаар цацахад бэлэн болсон.
2. Байгаль ба хүн сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулах, өргөн нэвтрүүлгийн 2 сувгаар цацахад бэлэн болсон.
3. Амьтад ба хүн сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулах, өргөн нэвтрүүлгийн 2 сувгаар цацахад бэлэн болсон.
4. Ус ба хүн сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулах, өргөн нэвтрүүлгийн 2 сувгаар цацахад бэлэн.
5. Дээрх дөрвөн контентыг нэгтгэсэн урт хувилбар буюу 15 минутын контентыг олон нийтийн сүлжээнд байршуулж, өргөн нэвтрүүлгийн 2 сувгаар цацахад бэлэн болсон – (МҮОНТ, NTV-суваг телевиз, Сошиал суваг-Facebook)

Контентоос авах мэдээллийн үр дүнд:

- Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан тусгай хамгаалалттай газар нутгийн онцлог, хүн байгаль, зэрлэг ан амьтантай зөв зохистой харилцааг олон нийтэд түгээх, таниулах, сурталчилах, мэдээллээр хангасан.
- Байгаль орчны доройтол болон байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудыг олон нийтэд таниулсан.
- Байгаль хамгаалагчийн ажлын онцлог, тулгамдаж буй асуудлын тухай бодит мэдээллээр хангасан.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн давуу талуудыг олон нийтэд таниулах.
- “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн үйл ажиллагааг олон нийтэд өргөнөөр таниулсан;

Контентуудын ерөнхий санаа:

“Төслийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, контент боловсруулах, танилцуулах” ажлын хүрээнд хийгдэх контентуудын зохиолын санааг захиалагч талтай нарийвчлан тохирох, сэдвийн хүрээнд харуулахыг зорьж буй санаануудыг нэгтгэх уулзалт хурлыг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр БОАЖЯ-ны хурлын танхимд хийсэн. Хуралд захиалагч талаас БОАЖЯ-ны хэвлэлийн албаны дарга Ц.Үүрцайх, Тусгай хамгаалалттай газрын бодлого зохицуулалтын газрын шинжээч М.Мөнхзаяа гүйцэтгэгч талаас “И ЭМ ТЕХНОЛОГИ” ХХК-ийн найруулагч Н.Батбилэг, ерөнхий продюсер У.Даваасүрэн, үйл ажиллагааны менежер Б.Тэргэлмаа нар оролцов. Тайланд хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулан хавсаргасан болно. Тус уулзалтаас дараах санаануудыг контентод тусгахаар тохиролцсон.

- Байгаль хамгаалагч нарын ажил яг ижилхэн. Цас бороо байгалийн хатуу үзэгдэл гэхгүй бүх зүйлд тэд явж байдаг. Гэхдээ нутаг орны газарзүйн байршлаас хамааран өөр, өөр саад бэрхшээлүүдтэй тулгарч байдаг. Тэдний нэг өдрийн ажлын процессыг энгийнээр үзүүлж, тухайн орон нутгийн онцлогийг тодотгон, тулгамдах асуудлууд болон эрсдэлийг харуулж тэдний ялгарлыг түлхүү илэрхийлэх нь чухал.
- Газар нутгийг тусгай хамгаалалтад авч, эзэнтэй болгосноор ямар үр ашигтай вэ гэдгийг тодорхой үзүүлэх, тусгай хамгаалалттай газарт анхаарал тавьж хамгаалсны хүчинд ургамал ус нь хүртэл зөв ургаж экологийн систем нь алдагдахгүй үргэлжилдэг. Ингэснээр ан амьтад өсөж үржих, байгаль орон үзэсгэлэнт байдлаа алдахгүй өнө орших гэх мэт олон давуу талтай байдаг.
- Монголчууд эзэрхэг үзэлтэй хэр нь цэвдэг байдгийг харуулах. Өөрөөр хэлбэл хээрээр амарч зугаалж явахдаа дуртай газраа бууж тухалчхаад хөрс газар сэндийчихийн хажуугаар хаа хамаагүй хог хаяна. Буцахдаа буйраа ч цэвэрлэхгүй, ховордож цөөрсөн ан амьтдыг хайр найргүй гөрөөлөх зэрэг.
- Байгал хамгаалагчдын өдөр тутмын ажил амьдралыг ядаж 7 хоног тасралтгүй дагаж харуулж өгөх.
- **Говь** цөлийг Говийн Б бүс дээр, ойт хээр тайгыг Ханхөхийд, Мянган угалзат дээр ховор ан амьтдыг, Увсад нуур усыг харах боломжтой. Хянан шалгалтыг хамтарсан багаар хийдэг нь онцлог үүнийг харуулах хэрэгтэй. Мөн хээрийн дулаацуулах байр гэж байдаг. Бүх тахид сансрын дохиолол хийсэн байдаг. Үүн дээр үргэлж мониторинг хийж байдаг. Энэ онцлогуудыг харуулах.
- **Ханхөхий** нь ой, тайга, нууртай. Хууль бус ан, хууль бус байгалийн нөөц ашиглалттай байгаль хамгаалагч нар хэрхэн тэмцэж байгааг харуулах.
- **Мянган угалзат** нь аргал угалзаараа маш баялаг. Тиймээс ангийн бүс бүслүүр, ангийн менежмент гэж юу вэ? Үүний судалгаа шинжилгээний ажилд байгаль хамгаалагч хэрхэн оролцдог тухай, амьтнаа яаж тоолж яаж бүртгэлжүүлдэг тухай гэх мэт ахуйг нь тодорхой харуулах мөн тухайн газрын байгалийн нөхцөл нь их хүнд. Тиймээс тэр хүнд нөхцөлийг сайн харуулах, (валфром орж ирсэн, энэ кейсийг тодруулан ашиглах)
- **Увс нуур** нь хил дамнасан тусгай хамгаалалттай газар. Дэлхийн өвд бүртгэлтэй маш онцлог газар. Эко системийн хувьд зургаан бүслүүр зургуулаа байдаг. Дэлхийд хосгүй өв учраас хосгүй гэдэг талаас нь харуулах нь зөв.
- Байгаль хамгаалагчдын ар гэрийн амьдралыг харуулах.

- Анхан шатны нэгжийн удирдлага зөв явж байгаа эсэхийг байгаль хамгаалагч нар өөрсдөөр нь харуулах (хэлүүлэх, яамны бодлого, БОАЖЯ-ны бодлогыг сайн уяж харуулах)
- Байгал хамгаалагч гэдэг нь судлаач хүн учир агуулгын хувьд нэг талаасаа судалгаа шинжилгээ нь харагдах нөгөө талаасаа хяналт шалгалт хийж тулгамдсан асуудлуудтай шууд нүүр тулдаг маш эрсдэлтэй нөхцөл байдалд ажилладаг аврагч байдаг. Мөн байгалиа хүмүүст сурталчилж ойлгуулж нутгийн иргэдтэй ойр дотно ажилладаг. Тэр хэрээр хүн байгалийн харилцаа эерэг болж байдаг талаас нь харуулах
- Уламжлалт байгаль хамгаалах аргууд байдаг. Үүнийг харуулахын сацуу удирдлагаас хангаж өгсөн тоног төхөөрөмжтэй ажиллаж буй байдлыг буюу шинэ дэвшилтэд аргууд ашиглаж байгааг харуулах
- Жишээ нь Увс нуурыг ганцхан хүн харж хамгаалдаг. Тэр хүнээс ямар их сэтгэл ур чадвар гарч байгааг энгийнээр хэр нь ойлгомжтой харуулах нь чухал
- Эцсийн үр дүнд тусгай хамгаалалттай газар нь яагаад ийм үнэ цэнтэй, ач холбогдолтой вэ гэдгийг хүмүүст ойлгуулах. Үүнийг хамгаалсан нь ямар ач холбогдолтой вэ гэдгийг хүн бүр ойлгох хэрэгтэй. Нөгөө талаасаа байгаль хамгаалагч гэж яг хэн бэ гэдгийг таниулах ёстой. Мөн нутгийн иргэн, бэлчээр, хадлан, байгаль хамгаалагч нарын хоорондын зохилдлогоо алдагдсанаар асуудал үүсэж байгааг харуулах
- Монгол улсыг хамгаалах нь бусад улс орны байгаль экологийн хувьсалд өндөр нөлөөтэй. Үүнийг маш энгийнээр харуулах.
- Олон нийт иргэд ямар ухамсаргүй амьдарч байгаагаа мэдэх нь чухал. Тухайн нутгийг нутгийн иргэд нь хамгийн ихээр сүйтгэж байдаг. Үүнийг мөн л энгийнээр харуулах.
- Манай контентууд агуулгаараа жижиг тасрах боломжтой байх. Мөн харьцуулалт хийх.
- Контентын далд санаа нь “Эх орныхоо үнэ цэнийг мэдрүүлсэн, бахархал төрүүлсэн гайхалтай газар нутаг, мөн хүн гэдэг нь өөрөө байгалийн нэг хэсэг. Байгаль гэдэг нь бүх дэлхий гэдгийг харуулах”
- Мөн зураг авалтын үеэр гарсан нөхцөл байдлаас ургуулан энгийн бөгөөд гайхамшигтай зураглалыг харуулах

Бид цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас зураг авалтын баг төлөвлөгөөт хугацаанаасаа бага зэрэг хоцорч замдаа гарсан бөгөөд Улаанбаатар – Ховд – Говь-Алтай – Увс – Улаанбаатар маршрутаар 4 хүний бүрэлдэхүүнтэй нийт 4200 км замыг туулж, 10 хоног ажиллаа.

Эхний зураг авалтын цэг болох Ховд аймгийн цэцэг сумын нутагт байрших Мянган угалзтын нурууны БТХГ-г очиж, байгалийн тусгай хамгаалалттай газрын мэргэжилтнүүд болон мянган угалзтын ой хамгаалагч нартай судалгаанд явж аргаль, угалз, янгирын сүрэгт тооллого хийх, цаг агаарын нөхцөл байдалтай танилцах зэрэг байгаль хамгаалагч нарын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцан зураг авалтыг явуулж, нэвтрүүлэгт бэлдлээ.

Эхний цэг дээр 2 хоног ажилласны дараа бидний дараагийн цэг болох хамгийн том байгалийн цогцолбогт газар болох Говь-Алтай аймгийн Говийн Их Дархан Цаазат газрын Б хэсэгт очиж мэргэжилтэн, байгаль хамгаалагч нартай хамтран ажиллаж тахь ус, хонь ус цэгүүд дээр очиж тахийн нутгаар явж, нэвтрүүлгийн бэлтгэл ажил хийлээ.

Үүний дараа сүүлийн аймаг буюу Увс аймгийн байгалийн тусгай хамгаалалттай газар нутаг болох Увс нуур, болон Хан хөхийн нурууны байгалийн ТХГ нутагт очиж зураг авалт хийсэн бөгөөд байгаль хамгаалагчдын ажлын нөхцөл байдал, ТХГ-ын хамгаалалтад ашиглаж буй техник технологийн дэвшил, байгалийн онцлог зэргийг түлхүү гаргасан зураг авалтыг хийлээ.



Зураг авалт хийгдэж байна.



- Ерөнхий санаа: Байгаль хамгаалагч нарын ажил ижилхэн. Тэд цас бороо байгалийн хатуу үзэгдэл гэхгүй бүх зүйлд тэд явдаг. Гэхдээ нутаг орны газарзүйн байршлаас хамааран өөр, өөр саад бэрхшээлүүдтэй тулгарч байдаг. Тэдний нэг өдрийн ажлын процессыг энгийнээр үзүүлж, ахуй нөхцөл байдал өөр өөр байдаг ялгарлыг, тухайн орон нутгийн онцлогийг тодотгон говь, хангай, усны газруудын ялгаа, тулгамдаж буй эрсдэл, асуудлууд, мөн уламжлалт болон орчин үеийн арга техникийг ажлын нөхцөлдөө ашигладаг талаар түлхүү илэрхийлсэн.
- Эдгээр санааг нэгтгэн, илэрхийлсэн дараах ялгаатай зураг авалтуудыг хийсэн бөгөөд тусгай хамгаалалттай газар тус бүрт өөр өөр онцлогийг харуулсан болно.

Говийн их дархан цаазат газрын Б хэсэг

- Говь цөлийн байгаль, аргаль, угалз, тахийн зураг
- Байгаль хамгаалагч хяналт шалгалтыг багаараа хамтарсан байдлаар хийж буй зураг авалт, хээрийн дулаацуулах байр, сансрын мониторинг, хөрөнгө оруулалтын үр өгөөжтэй байдлын тухай зураг авалт.
- Байгаль хамгаалагч нутгийн иргэд, зэрлэг ан амьтад тэдгээрийн уялдаа холбоо, ойлголцол харуулсан ярилцлага /иргэн/ зураг авалт
- Ажлын зураг авалт



Увс нуурын УТХГН

- Хил дамнасан тусгай хамгаалалттай газрын онцлог, сав газрын хамгаалагч, байгалийн зураг, дүрс
- Дэлхийд хосгүй гэдэг талаас нь гаргасан байгалийн үзэсгэлэнт дүрс /зуны зураг/
- Байгаль хамгаалагч өмнө нь олон мянган км-ийг явган туулдаг байсан бол одоо орчин үеийн техник технологийн тусламжтайгаар хэрхэн цагаа хэмнэж буй талаар мөн бодит хөрөнгө оруулалтын талаарх баяжуулсан дүрс, байгаль хамгаалагчийн ярилцлага
- Ажлын зураг авалт



Хан хөхий нурууны УТХГН

- Ар гэрийн сэтгэгдэл, өмнө нь тохиолдож байсан кейс ярилцлага
- Хулгайн анчидтай тэмцэж буй, хүнд хэцүү хяналт шалгалтыг хэрхэн хийдэг кейс зураг авалт
- Хууль бус нөөц ашиглалт
- Ойт хээр тайгын зураглал
- Ажлын зураг авалт



Мянган угалзтайн нурууны БЦГ

- Ан амьтад, тэдгээрийг хэрхэн бүртгэх, ангын менежмент гэж юу байдаг, судалгаа шинжилгээний ажлыг хэрхэн хийдэг, шархадсан гэмтсэн амьтдыг хэрхэн эмчилж буй тухай ярилцлага кейс зураг авалт
- Байгаль хамгаалах уламжлалт аргууд
- Ажлын зураг авалт



Эцэст нь тусгай хамгаалалтад байснаар ямар ач холбогдол давуу талтай вэ, байгаль хамгаалагч гэж хэн бэ? Ямар үнэ цэнтэй вэ? Хүн байгалийн зохилдлогоо харилцан хамаарлыг үзэх болно.

**Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
II, III төсөл BMZ №2016 67 054, 2018 68 272 ажлын гүйцэтгэлийн хяналт**

Байгаль орчин аялал жуулчлалын яамны 23/259 дугаартай Төслийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, контент боловсруулах, танилцуулах № ГШБ-4.04/2123 гэрээний дагуу дараах ажил үүргийг гүйцэтгэн хянууллаа.

Богино 5 минутын 4 контент, 4 контентыг нэгтгэсэн урт хувилбар буюу 15 минутын 1 контент, 1 минутын 8 ширхэг Рийл/REEL хийн олон нийтийн цахим сүлжээнд түгээх. Тус контентуудыг өргөн нэвтрүүлгийн 2 телевизээр (MYOHT, NTV) олон нийтэд нэвтрүүлэх юм.

Гүйцэтгэсэн ажил: Тус ажлын хүрээнд дараах 5 бүтээгдэхүүнийг гаргаж төслийн захиалагчид хүргүүлсэн. Үүнд:

6. Байгаль хамгаалагч гэж хэн бэ? сэдэвт богино хэмжээний контентыг олон нийтийн сүлжээнд байршуулахад бэлэн болсон. Энэхүү контентийн гол санаа нь байгаль хамгаалагчын өдөр тутмын үйл ажиллагаа болон, ажлын хүнд нөхцөл байдал, мөн тэдний ард үлдсэн гэр бүлийн сэтгэл санааны байдал, байгаль хамгаалагчдын ажлын нөхцөл хэрхэн сайжирсан зэргийг харуулахыг зорилоо.

7. Байгаль ба хүн сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулахад бэлэн болсон. Энэхүү контентийн ерөнхий санаа нь хүн бол байгалийн нэгэн салшгүй хэсэг бөгөөд байгаль бидэнд, хүн төрөлхтөнд маш их ач холбогдолтой байдаг тухай, мөн хүн байгальтай зүй зохисгүй харьцаж байгаа, түүнээс гарах сөрөг үр дагаварын тухай, байгаль хамгаалагч нар хууль бус анчид, зөрчил гаргасан аялагч, иргэдтэй тэмцэхэд хэрхэн хүчин мөхөсдөж байгаа тухай харуулахыг зорилоо.

8. Амьтад ба хүн сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулахад бэлэн боллоо. Энэхүү контентоор устаж үгүй болж буй амьтадыг аврах, хамгаалах, тэдгээрийг нутагшуулах, хүн төрөлхтөн, зэрлэг ан амьтдын мониторинг судалгааг хийх, багаж материал, байгаль хамгааллын ажлын байр зэргийг харуулахыг зорилоо.

9. Ус ба хүн сэдэвт богино контентыг олон нийтийн сүлжээнд байршуулахад бэлэн болсон. Ус бол хүний амьдралын амин чухал хэрэгцээ байгалийн шавхагдах нөөц бөгөөд Увс нуур нь байгалийн шим мандалын нөөцөд бүртгэлтэй, бид бүхний хамгийн хайрлан хамгаалах ёстой эко системийн газар нутаг юм.

10. Дээрх дөрвөн контентыг нэгтгэсэн урт хувилбар буюу 15 минутын контентыг олон нийтийн сүлжээнд байршуулж, өргөн нэвтрүүлгийн 2 сувгаар цацахад бэлэн болсон – (MYOHT, NTV-суваг телевиз, Сошиал суваг-Facebook)

Мөн эдгээр контентуудтай холбоотой 1 минутын 8 рийл, 15 минутын 1 нэвтрүүлэг хүргүүллээ.

Эдгээр контентийн ерөнхий санаа нь хүн төрөлхтөн, бид бүгдээрээ байгаль хамгаалагч юмаа гэсэн санааг харуулсан нэвтрүүлэг боллоо гэж дүгнэж байна.

Контент бүр өөр өөр утга санааг агуулсан бөгөөд сэдэв бүр нь тус тусын газар нутагт зураг авалтыг хийлээ.

5. Мянган угалзатын нурууны БЦГ – Байгаль хамгаалагч гэж хэн бэ сэдэв
6. Говийн их ДЦГ-ийн Б хэсэг – Амьтад ба хүн сэдэв
7. Хан хөхийн нурууны ЦТХГН – Байгаль ба хүн сэдэв
8. Увс нуурын УТХГН – Ус ба хүн сэдэвийн зураг авалтуудыг хийлээ.

Хянасан нь: БОАЖЯ хэвлэл мэдээллийн газрын дарга Ц. Үүрцайх контентуудыг үзэж, өөрийн санаа, засварлах дараах саналуудаа өгсөнийг засварласан болно.

Ерөнхий 15 минутын КОНТЕНТ:

1. Эхлэл болон дундуур огцом орж ирэх адал явдалт киноны хөгжмөө солих
2. Текстийн агуулгадаа анхаар, Дэлхийн хүн төрөлхтөн гэдэг агуулгад монгол хүн чинь ч бас орно ш дээ.
3. Тусгай хамгаалалтын бүс нутаг, хамгаалалтын захиргааны үүрэг, үндсэн агуулга орхигдсон байна.
4. Төгсгөлийг Дэд сайдын яриагаар дуусгах, учир нь Дэд сайдаасаа илүү байгаль хамгаалагч нь илүү мэдээлэлтэй харагдаад бна.
5. План үсрэлтүүд их бна,
6. Яам муу ажиллаал Төсөл мундаг ажиллажээ гэдэг мессэжийг засах, олон Улсын төслүүд яаман дээрээ тулгуурлаж явдаг ба хамтын ажиллагааны дүнд ажил явдаг, үр дүн гардаг.

БОГИНО КОНТЕНТУУД

1. Агуулгаа илүү богино хугацаанд багасга, самарчдын хүмүүсийн царайг блүүрдэх, сошиалд зөвшөөрөлтэй ая тавих, киноны хөгжмүүдээ хас, зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй юу,,
2. Rocky киноны хөгжмөө хас, эх орон юунаас эхэлдэг вэ гэдэг өнцөг гаргах гэж бгаа бол агуулгаа гүйцээх хэрэгтэй.
3. Дууны алдаа бна,,баранк бна
4. Ерөнхий агуулга алга, Засгийн газар Яамны бодлого шийдвэрийг тодорхой хэмжээнд тусгах, эсвэл зөвхөн KFW-аа л гарга, тэр хүрээнд хийх,
5. 5 минутын контентын хугацааг 3 мин болгох саналтай бна хэтэрхий нуршсан бна.
6. Төрийн буюу Засгийн газрын төлөөлсөн контент учир стандарт, чанарыг чухалчлах,
7. Дэд Сайдыг үүрэгтэй оруулах, энгийн жуулчин шиг харагдаад бна. Үүнд анхаарах хэрэгтэй.

Шийдвэрлэсэн нь: Дээрх саналуудыг тус бүрд нь буюу дуу, дүрсний алдаа, найруулга, хөгжимийн алдаа зэргийг дахин засварлаж, стандарт чанарт анхаарч, засварлаж дуусгасан бөгөөл нэмэлтээр дэд сайд Ганбаатарын яриаг орууллаа.

Гүйцэтгэж, тайлагнасан:

“И Эм Технологи ХХК” –ийн захирал
Ерөнхий менежер, продюсер
Найруулагч



Ц. Билэгсайхан
У. Даваасүрэн
Н. Батбилэг